

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

/2015 оны 11 дүгээр сарын 13-ны байдлаар/

Д/Д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжилт
<i>Тулгуур 1: Авлигатай тэмцэх санал, санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх</i>				
1.	1.Авлигаас урьдчилан сэргийлэх удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх	1.1.ИНЕГ-ын удирдлагуудаас авлигатай тэмцэх, авлигаас ангид байх хүсэл эрмэлзлээ илэрхийлэх бусад байгууллагаас гаргасан санал, санаачилгыг дэмжих, нэгдэх <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u> <ul style="list-style-type: none"> • Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж, мэдэгдэл хийсэн байх; • Олон нийтэд хүрсэн байх; • Бусад байгууллагаас гаргасан санал, санаачилгыг дэмжсэн байх; 	II улирал	Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж, 2015 оны 11 дүгээр сарын 09-нд мэдэгдэл гаргасан. /Мэдэгдлийг хавсаргав./ <i>/Хэрэгжилт 100%/</i>
		1.2.Авлигын эсрэг үйл ажиллагаанд тодорхой хөрөнгийг төсөвлөх, зарцуулах <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u> <ul style="list-style-type: none"> • Шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлсэн байх • Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд холбогдох зардлыг зарцуулсан байх 	Жилдээ	Зам, тээврийн сайд, Сангийн сайдын 2015 оны 87/64 хамтарсан тушаалаар батлагдсан тус байгууллагын харьяа үйлдвэрлэл, үйлчилгээний албадын 2015 оны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан мэдээлэл сурталчилгааны 86 сая төгрөгийн тодорхой хэсгийг авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн. Байгууллагын үйл ажиллагааг нийт ажилтнуудад ил тод, нээлттэй байлгах, авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг тогтмол мэдээлэх зорилгоор ажилтан, албан хаагчдын нийтийн унаанд мэдээллийн дэлгэц суурилуулж, нийт ажилтнуудыг мэдээллээр хангаж байна. <i>/Хэрэгжилт 100%/</i>

		<p>1.3.Тухай жилд авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын цахим хуудасны ил тод мэдээллийн буланг тасралтгүй ажиллуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> • <i>Байгууллагын цахим хуудас Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2011 стандартад нийцсэн, иргэд харилцагч нарт мэдээлэл нээлттэй байж хэвшсэн байна.</i> 	Жилдээ	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтэд заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд оруулж, тогтмол шинэчилж байна.</p> <p>http://www.mcaa.gov.mn/?page_id=11230#</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
Тулгуур 2. Албан хаагчийн шударга байдлыг хангах				
2.	Албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх шударга байдлыг нэмэгдүүлэх	<p>2.1.Ажилтан, албан хаагчдад шударга ёс, ёс зүйг төлөвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх талаар мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> • 2 удаа сургалт зохион байгуулсан байна. 	Жилд 2 удаа	<p>АТГ-тай хамтран 2015 оны 11 дүгээр сарын 25-нд сургалт зохион байгуулахаар тохироод байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 30%/</p>
		<p>2.2.Ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлэх, байгууллагын дотоод хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчилд хариуцлага тооцож ажиллах, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p>	Тухай бүр	<p>ИНЕГ-ын даргын 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 564 дүгээр тушаалаар Ёс зүйн дүрмийг батлуулан, мөрдөж байна. Уг дүрмийг 2015 оны 11 дүгээр сарын 10-нд нийт ажилтнуудад танилцуулан, тус байгууллагын ёс зүйн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Ёс зүйн хороонд 2015 онд зөрчлийн талаар гомдол ирээгүй.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 90%/</p>

		<ul style="list-style-type: none"> • Зөрчлийн талаарх бүртгэл хөтөлсөн байна. • Илрүүлсэн зөрчилд хариуцлага тооцож, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. • Ёс зүйн дүрэмд АТГ-аас санал авч тусгасан байна. • Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байна. 		
Тулгуур 3. Ил тод байдлыг хангах				
3.	3.Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах	<p>3.1.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг цахим хуудсанд мэдээлэх гадагш чиглэсэн шалгалт хамаарна.</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> • Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөж, дүнг цахим хуудсаар мэдээлсэн байна. 	Жилдээ	<p>“2015 онд дотоод аудит хийх төлөвлөгөө”-г боловсруулж, ИНЕГ-ын даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу нийт 26 төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудит шалгалт хийсэн. Үүнд: 2015 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилт - ИНЕГ-ын 2015 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлд, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоол, Зам, тээврийн сайдын 2013 оны 68 дугаар тушаал, 2014 оны 13 дугаар тушаал, ИНЕГ-ын даргын 2013.04.10-ны А/144 дүгээр тушаал, 2013.05.01-ны А/192 дугаар тушаал, 2014.12.06-ны А/700 дугаар тушаал, 2015.01.06-ны Б/01 дүгээр тушаалын хэрэгжилтэд, байгууллагын санхүүгийн байдлыг 2015 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэлд, 2014 оны орон сууцны хөнгөлөлтийн олголтод, ИНЕГ-ын 2014 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд, “Чингис хаан” ОУНБ-ын үндсэн үйл ажиллагаанд, Орон нутгийн 9 нисэх буудлын 2013, 2014 оны санхүүгийн үйл ажиллагаа гэх мэт. Мөн Чингис хаан Олон улсын нисэх буудалд худалдаа, үйлчилгээ явуулж буй газруудад хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан. Аудитын үр дүнг удирдлагад танилцуулж, ИНЕГ-ын даргын тушаалаар тодорхой үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>

		<p>3.2.Шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Шалгалтын мөрөөр хийсэн ажлын дүнг олон нийтэд мэдээлсэн байна. 	Жилдээ	<p>Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч залруулах зорилгоор нийт 79 зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Энэ оны 11 дүгээр сарын 11-ний байдлаар зөвлөмжийн хэрэгжилт 76%-тай байна. Мөн ИНЕГ-ын даргын 5 тушаалаар / А/455, А/369, А/370, А/452, А/613/ хугацаатай үүрэг өгч, тушаалын хэрэгжилтэд эргэн хяналт тавьж, хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг авч, Хууль, эрх зүй газрын даргад танилцуулж байна. Мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
4.	4.Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээг авах, Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	<p>4.1.Жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байрлуулсан байх</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулсан байна. 	Хуулийн хугацаанд	<p>2014 жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг тус байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p> <p>http://www.shilendans.gov.mn/main/agency/9746</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
		<p>4.2.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсноос хойш 14 хоногт багтаан цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт багтаан цахим хуудсанд байршуулсан байна. 	Тухай бүр	Одоогоор 2015 оны төсөвт өөрчлөлт ороогүй байна.
		<p>4.3.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг эхийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилж байх</p>	Жилд	<p>Мэдээллийг цахим хуудсандаа байршуулж, тухай бүр шинэчилж байна.</p> <p>http://www.shilendans.gov.mn/main/agency/9746</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>

		<p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Нийгмийн даатгалын сангаас тэтгэвээ, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан байна. 		
		<p>4.4.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна. 	Тухай бүр	<p>Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэгжийн цахим хуудсыг тус байгууллагын цахим хуудастай холбож, хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлсэн. http://www.nubia.mn</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
5.	5.Зөвшөөрөл бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	<p>5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардагдах баримт бичиг, шийдвэрлэх журмын талаарх мэдээллийг ил тод болгох</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. 	1 улирал	<p>ИНЕГ-аас олгож буй тусгай зөвшөөрөл, үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл, эрх олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт болон уг асуудлыг шийдвэрлэх дүрэм, журмуудыг цахим хуудсанд байршуулсан. <u>Агаарын тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:</u> http://srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=24&id=111&Itemid=141</p> <p><u>Бүртгэлтэй агаарын хөлгийн талаарх мэдээлэл:</u> http://srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=12&id=118&Itemid=164</p> <p><u>Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн талаарх мэдээлэл:</u> http://srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=16&id=92&Itemid=117</p> <p><u>Аэродром</u> http://srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=13&id=91&Itemid=114</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
		5.2.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх	Жилдээ	<p>Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчдийн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p>

		<p>үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулсан байна. 		<p>http://srd.mcaa.gov.mn//index.php?option=com_content&task=category&sectionid=24&id=111&Itemid=141</p> <p><i>/Хэрэгжилт 100%/</i></p>
6.	6. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	<p>6.1. Сул ажлын байрны зар болон сонгон шалгаруулалт явуулах журмын талаар цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах, сонгон шалгаруулалтыг үндэслэн иргэдийг ажилд авах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Сул ажлын байрны зар болон сонгон шалгаруулалт явуулах журмыг цахим хуудсанд байршуулсан байна. Сонгон шалгаруулалтыг үндэслэн иргэдийг ажилд авах ажлыг зохион байгуулсан байна. 	Жилдээ	<p>Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p> <p>http://www.mcaa.gov.mn/?page_id=11890</p> <p><i>/Хэрэгжилт 50%/</i></p>
		<p>6.2. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчлэх</p>	Жилдээ	<p>ИНЕГ-ын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/650 дугаар тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн стратеги /2014-2016 он/”-ийн 2.3.5-д стратегийн хэрэгжилтийг үнэлэх талаар тусгасан.</p> <p>http://www.mcaa.gov.mn/?page_id=11890</p>

		<p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг боловсруулж, батлуулан, байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. 		/Хэрэгжилт 70%/
7.	7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	<p>7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлэх</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлсэн байна. 	Тухай бүр	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг http://www.shilendans.gov.mn/main/agency/9746 1 дүгээр сарын 10-ны дотор цахим хуудсанд байршуулсан бол тендерийн урилгыг http://www.mcaa.gov.mn/?cat=292 энэ оны 10 дугаар сарын 01-нээс тус байгууллагын цахим хуудсанд байршуулж байна. Тендерийн урилгыг өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслэл болох Монголын мэдээ, Өдрийн сонинд нийтэлж байна.</p> <p>/Хэрэгжилт 100%/</p>
		<p>7.2.Тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар нийтэд танилцуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u></p> <ul style="list-style-type: none"> Тендерт оролцохыг сонирхогчдод тавих 	Тухай бүр	<p>Тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлтийг тендерийн урилгад тусгаж өгч байгаа бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаарх мэдээллийг шилэн дансанд байршуулж байна.</p> <p>http://www.shilendans.gov.mn/main/agency/9746</p> <p>/Хэрэгжилт 100%/</p>

		шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар нийтэд мэдээлсэн байна.		
		7.3. Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайланг цахим хуудсанд мэдээлэх <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u> <ul style="list-style-type: none"> Тайланг цахим хуудсанд байршуулсан байна. 	Тухай бүр	Худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайланг хуулийн хугацаанд шилэн дансанд оруулж, байнга шинэчилж байна. http://www.shilendans.gov.mn/main/agency/9746 /Хэрэгжилт 100%/
		7.4. Тендер шалгаруулах явцад гарсан зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u> <ul style="list-style-type: none"> Тендер шалгаруулах явцад гарсан зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байна. 	Тухай бүр	Тендер шалгаруулах явцад гарсан зөрчлийн талаар тухай бүр Сангийн яаманд мэдээлж байна. /Хэрэгжилт 100%/
		7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт:</u> <ul style="list-style-type: none"> Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад 	Тухай бүр	Энэ онд худалдан авах ажиллагаанд аудит хийгээгүй.

		<p>хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болон бусад хэлбэрээр нээлттэй мэдээлсэн байна.</p>		
8.	8. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах	<p>8.1. Үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, эрх бүхий тушаалтнаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, эрх бүхий тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. 	Жилдээ	<p>Үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль, дүрмийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан.</p> <p>http://www.mcaa.gov.mn/?page_id=13386</p> <p>/Хэрэгжилт 100%/</p>
		<p>8.2. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр хураамжийн талаарх мэдээллийг ил тод байлгах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээний төлбөр хураамжийн талаар мэдээллийг байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байна. 	Жилдээ	<p>Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийг ИНЕГ-ын цахим хуудсанд http://www.mcaa.gov.mn/?page_id=6768, Нисэх буудлын үйлчилгээний үнэ тарифыг “Чингис хаан” ОУНБ-ын цахим хуусанд www.airport.mn тус тус байршуулсан.</p> <p>/Хэрэгжилт 100%/</p>
		<p>8.3. Бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> • Шийдвэрийн төслийг цахим хуудсанд 	Тухай бүр	<p>Иргэний нисэхийн салбарын бодлогын баримт бичиг боловсруулахдаа мэргэжлийн шинжээч, иргэдийг саналыг авч, холбогдох саналыг баримт бичгийн төсөлд тусгаж хэвшсэн. Мөн иргэний нисэхийн багц дүрмийн болон стандартын төслийг байгууллагын цахим хуудсанд 30 хоног байрлуулан, санал авч байна. Мөн дүрмийн төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулж, түүнээс гарсан санал, зөвлөмжийг баримт бичгийн төсөлд тусгаж байна.</p>

		<i>байршуулж, иргэд сонирхогчийн бүлгийн саналыг авсан байна.</i>		http://www.mcaa.gov.mn/?page_id=12266 <i>/Хэрэгжилт 100%/</i>
9.	9. Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах, хариу өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох	9.1.Өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u> <ul style="list-style-type: none"> • <i>Өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байна. /Утас, факс, хайрцаг, цахим, бичгээр, амаар/</i> 	<i>Жилд</i>	Өргөдөл, гомдлыг хүлээн авах ажилтны утас, факсийн дугаарыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, санал хүсэлт хүлээн авах хайрцагийг тус байгууллагын төв оффист байрлуулсан. Мөн “Чингис хаан” олон улсын нисэх буудалд санал хүсэлт хүлээн авах 1980 тусгай дугаарын утас ажиллуулж, 6 ш санал авах хайрцаг байрлуулж, үйлчилгээний танхимуудад санал, гомдлын дэвтэр тавьж, зорчигчид санал, гомдлоо гаргах нөхцлийг бүрэн бүрдүүлсэн. <i>/Хэрэгжилт 100%/</i>
		9.2. Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u> <ul style="list-style-type: none"> • <i>Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байна.</i> 	<i>Улирал</i>	Захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог нэр, утасны дугаар, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, ажиллах журмыг тус байгууллагын цахим хуудасны холбоо барих хэсэгт байршуулсан. Иргэдийн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар процедурыг тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан. http://www.mcaa.gov.mn/?page_id=11243 <i>/Хэрэгжилт 100%/</i>
		9.3. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр тогтмол мэдээлж хэвших	<i>Улирал бүр</i>	Хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр мэдээлээгүй байна. <i>/Хэрэгжилт 0%/</i>

		<p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> Шийдвэрлэлтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр мэдээлсэн байна. 		
Тулгуур 4. Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх				
10.	10. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, иргэд байгууллага мэдээллийг чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх	<p>10.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд нээлттэй мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хууль тогтоомжийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. 	1 улирал	<p>АТГ-аас ирүүлсэн сурталчилгааны материалыг бүх харьяа байгууллагуудад хүргүүлж, бүртгэл хөтөлсөн. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор байгууллагын цахим хуудсанд холбогдох хууль тогтоомжийг байршуулсан.</p> <p>http://www.mcaa.gov.mn/?page_id=11230</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
		<p>10.2.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэж, ажилтнуудад танилцуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, ажилтнуудад танилцуулсан байна. 	11 сард	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ИНЕГ-ын даргаар 2015 оны 02 дугаар сарын 13-нд батлуулан, хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ оны 11 дүгээр сарын 13-ны байдлаар гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулсанаас гадна байгууллагын мэдээллийн самбарт мэдээллийг тавьсан.</p> <p>http://www.mcaa.gov.mn/?page_id=11230</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>
11.	11. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	<p>11.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлэх</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 	2015.11.15	<p>Төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ оны 11 дүгээр сарын 13-нд АТГ-т хүргүүлсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100%/</p>

		<p>хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Тогтоосон хугацаанд тайланг АТГ-т хүргүүлсэн байна. 		
12.	12. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	<p>12.1.ИНЕГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг томилж, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> • Ажилтан бүр нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлсэн байна. • Хариуцсан ажил үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа нээлттэй байршуулсан байна. 		<p>ИНЕГ-ын даргын 2015 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Б/29 дүгээр тушаалаар ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг томилж, давхардсан тоогоор 179 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>
13.	13.Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	<p>13.1.Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага иргэдийг судлан сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах</p> <p><u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u></p> <ul style="list-style-type: none"> • Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. • Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байна. 		<p>Монгол Улсын Зам, тээврийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Монголын Агаарын тээвэрлэгчдийн холбоо хамтран ажиллах гэрээг энэ оны 11 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан бөгөөд гэрээнд нисэхийн мэргэжлийн боловсон хүчний бодлогыг тодорхойлох, цаашид шаардлагатай боловсон хүчний судалгаа гаргах, тэдгээрийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байраар хангах ажлыг Монголын Агаарын тээвэрлэгчдийн холбоо хариуцахаар тусгагдсан. /Гэрээг хавсаргав./</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 90%/</p>

		<ul style="list-style-type: none"> • <i>Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслэл, цахим хуудсаараа мэдээлсэн байна.</i> 		
14.	14. Авлигын эсрэг хууль тогтоомуийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар АТГ-тай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	14.1 ЭБАТ-ныг томилж, үйл ажиллагааг нь тогтвортой ажиллуулах <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u> <ul style="list-style-type: none"> • <i>ЭБАТ-ыг томилсон байна.</i> • <i>ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод болон ажил үүргийн хуваарьт тусгасан байна.</i> 		ИНЕГ-ын даргын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/617 дугаар тушаалаар Эрх бүхий албан тушаалтанг томилж, албан тушаалын цалингийн 30%-ийн нэмэгдэл өгч байна. ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгасан. <i>/Хэрэгжилт 100%/</i>
15.	15. Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	15.1. Давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргах, албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн талаарх хүсэлтийг хүлээн авах зохих журмын дагуу шийдвэрлэх <u>Гүйцэтгэлийн үзүүлэлт</u> <ul style="list-style-type: none"> • <i>Хууль болон ЗГ-аас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байна.</i> • <i>Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаагаар байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог болсон байна.</i> 	Жилдээ	Давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргаж байна. <i>/Хэрэгжилт 30%/</i>
Хэрэгжилт -88.1%				